

Түргэн бодолтын тэмцээн

Манай орны нийслэлд зохиогдсон эмэгтэй шатарчдын ФИДЕ-гийн “Том цом”ын тэмцээний хүрээнд болсон Шатрын өдөрлөгийн үеэр “Монголын шатарчдын өдөр”-ийн (1955 оны 8-р сарын 10нд Монголын Шатрын Холбоо ФИДЕ-д гишүүнээр элссэн) нэрэмжит 20 минутын Түргэн бодолтын тэмцээн явагдан 20 гаруй шатарчид, бодлого сонирхогчид оролцсноос Чойжамц өгөгдсөн 2 бодлогын бүх хувилбаруудыг бүрэн зааж 6,5 оноогоор түрүүлэн Ч.Мөнхбат (18 минут), Т.Цагаан (20 мин.) нар 6 оноотой удаах байруудыг эзлэв. Т.Алтан 5,5 Номин-Эрдэнэ 5, И.Ганбаатар, Ч.Баттүвшин нар 4 оноо авч идэвхтэй оролцлоо.

Шүүгч Л.Тогоохүү